

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: О.Хэрлэнзаяа
Утас: 70357955 Цахим хаяг: Kherlenzayao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 84
танай _____-ны № _____-г

ОРХОН АЙМГИЙН 20 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Л.ОЧИРСҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 20 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

20 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	87,047,324.40	109,584,315.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	515,000.00	365,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	515,000.00	365,000.00
3121	Төгрөг	515,000.00	365,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	515,000.00	365,000.00
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	1,146,600.00	
335	Бусад авлага	1,146,600.00	
3351	Байгууллагаас авах авлага	396,600.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	750,000.00	
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	85,385,724.40	109,219,315.20
351	Түүхий эд материал	49,091,800.76	62,380,800.76
3511	Тусгай зориулалттай материал	49,091,800.76	62,380,800.76
354	Хангамжийн материал	36,293,923.64	46,838,514.44
3541	Бичиг хэргийн материал	1,078,900.00	1,561,200.00
3542	Аж ахуйн материал	1,426,750.00	517,400.00
3544	Түлш, шатах тослох материал	1,445,000.00	4,560,000.00
3547	Бусад хангамжийн материал	32,343,273.64	40,199,914.44
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,728,093,439.13	4,710,495,856.21
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,728,093,439.13	4,710,495,856.21
392	Биет хөрөнгө	4,359,007,212.60	4,341,542,629.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,400,762,886.00	4,400,762,886.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-222,203,788.56	-261,139,527.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,743,856.89	118,351,356.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-48,821,697.19	-59,422,389.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,479,510.25	197,584,510.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,953,554.79	-54,594,207.07
393	Биет бус хөрөнгө	369,086,226.53	368,953,226.51
39301	Програм хангамж	1,330,000.00	1,330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-553,773.47	-686,773.49
39303	Бусад биет бус хөрөнгө	368,310,000.00	368,310,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,815,140,763.53	4,820,080,171.41
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	56,800.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	56,800.00	
413	Өглөг	56,800.00	
4136	Бусад өглөг	56,800.00	
41361	Байгууллагад төлөх өглөг	56,800.00	
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		

422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,815,083,963.53	4,820,080,171.41
51	Засгийн газрын хувь оролцоо	4,815,083,963.53	4,820,080,171.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	368,310,000.00	368,310,000.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	4,446,773,963.53	4,451,770,171.41
5121	Өмнөх үеийн үр дүн	4,446,773,963.53	4,446,773,963.53
5122	Тайлант үеийн үр дүн		4,996,207.88
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,815,140,763.53	4,820,080,171.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,214,092,406.74	1,377,777,907.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,969,553.74	52,248,532.80
120	Нийтлэг татварын бус орлого	12,969,553.74	52,248,532.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,969,553.74	1,254,192.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	516,400.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,254,192.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,453,153.74	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		37,305,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		13,689,340.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,201,122,853.00	1,325,529,374.55
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,062,901,800.00	1,175,799,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,062,901,800.00	1,175,799,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		12,580,974.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,580,974.55
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,973,400.00	137,148,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,973,400.00	137,148,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,247,653.00	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,247,653.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,314,067,165.29	1,372,781,699.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,314,067,165.29	1,372,781,699.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,245,205,548.84	1,292,806,963.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	890,781,993.63	966,983,646.00
210101	Үндсэн цалин	690,198,093.00	964,645,595.00
210102	Нэмэгдэл	134,718,500.63	2,338,051.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,920,000.00	
210104	Урамшуулал	59,945,400.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,719,400.00	125,484,522.68

Ерөнхийн боловсролын 20-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	83,563,567.85	87,331,764.40
210202	Тэтгэмжийн даатгал	9,166,307.92	9,758,782.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,780,142.34	7,736,466.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,740,949.29	1,877,940.21
210205	Эрүүл мэндийн даатгал	17,468,432.60	18,779,568.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,947,386.70	111,995,052.06
210301	Гэрэл, цахилгаан	8,261,378.70	10,256,008.06
210302	Түлш, халаалт	45,305,000.00	46,635,000.00
210303	Цэвэр, бохир ус	40,381,008.00	55,104,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,867,541.00	9,624,100.00
210401	Бичиг хэрэг	2,974,880.00	2,293,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,161,000.00	1,057,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,516,241.00	1,101,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,215,420.00	5,172,400.00
2105	Нормативт зардал	176,500.00	1,193,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	176,500.00	411,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		782,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,588,500.00	3,394,500.00
210604	Урсгал засвар	2,588,500.00	3,394,500.00
2107	Томилолт, зочны зардал	94,600.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	94,600.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,143,000.00	4,760,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,000.00	4,760,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,886,627.51	69,306,942.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	315,000.00	665,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,455,400.00	10,331,860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	116,116,227.51	58,310,082.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,861,616.45	79,974,735.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,673,557.78	55,630,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	790,457.78	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,532,100.00	53,869,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,351,000.00	1,760,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	41,188,058.67	18,589,047.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,188,058.67	18,589,047.94
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		5,755,687.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,755,687.87
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-99,974,758.55	4,996,207.88
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-99,974,758.55	4,996,207.88

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,310,000.00		4,446,773,963.53	4,815,083,963.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Тайлант үеийн үр дүн			4,996,207.88	4,996,207.88
4	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,310,000.00		4,446,773,963.53	4,815,083,963.53
5	Тайлант үеийн үр дүн			4,996,207.88	4,996,207.88
6	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	368,310,000.00		4,451,770,171.41	4,820,080,171.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,221,192,232.78	1,334,177,361.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	516,400.00	1,650,792.00
120	Нийтлэг татварын бус орлого	516,400.00	1,650,792.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	516,400.00	1,650,792.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	516,400.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,650,792.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,220,675,832.78	1,332,109,569.55
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,062,901,800.00	1,175,799,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,062,901,800.00	1,175,799,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		12,580,974.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,580,974.55
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,973,400.00	137,148,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,973,400.00	137,148,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,800,632.78	7,393,795.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	21,800,632.78	7,393,795.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,221,327,232.78	1,333,910,361.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,221,327,232.78	1,333,910,361.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,455,441.33	1,247,355,430.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	891,531,993.63	960,798,768.68
210101	Үндсэн цалин	690,948,093.00	631,433,938.60
210102	Нэмэгдэл	134,718,500.63	260,486,333.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,920,000.00	3,131,310.00
210104	Урамшуулал	59,945,400.00	65,747,186.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,719,400.00	130,919,400.00
210201	Тэтгэврийн даатгал	84,247,000.00	92,206,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,868,100.00	9,678,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,094,500.00	7,742,600.00

Ерөнхийн боловсролын 20-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	1,773,600.00	1,935,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,736,200.00	19,356,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,692,386.70	115,110,052.06
210301	Гэрэл, цахилгаан	8,261,378.70	10,256,008.06
210302	Түлш, халаалт	45,050,000.00	49,750,000.00
210303	Цэвэр, бохир ус	40,381,008.00	55,104,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,276,091.00	9,179,150.00
210401	Бичиг хэрэг	560,280.00	1,452,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,161,000.00	1,277,000.00
210404	Ном, хэвлэл	507,300.00	850,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,503,041.00	542,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,544,470.00	5,057,550.00
2105	Нормативт зардал	1,250,970.00	2,011,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	211,500.00	813,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,039,470.00	1,198,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,274,500.00	3,449,500.00
210604	Урсгал засвар	2,274,500.00	3,449,500.00
2107	Томилолт, зочны зардал	94,600.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	94,600.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,143,000.00	8,260,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,000.00	8,260,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,472,500.00	17,562,060.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	315,000.00	665,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,157,500.00	13,489,560.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,871,791.45	86,554,930.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,683,732.78	62,210,195.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	21,800,632.78	6,580,195.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,532,100.00	53,869,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,351,000.00	1,760,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,967,058.67	18,589,047.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,967,058.67	18,589,047.94
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,221,000.00	5,755,687.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,221,000.00	5,755,687.87
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-135,000.00	-150,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		3,407,500.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах		3,407,500.00
	Дотоод эх үүсвэрээр		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-135,000.00	-150,000.00

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		515,000.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		365,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,314,562,900.00	1,289,440,856.19	98.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,314,562,900.00	1,289,440,856.19	98.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,258,932,900.00	1,235,439,480.74	98.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	962,822,300.00	960,798,768.68	99.79
210101	Үндсэн цалин	608,109,400.00	631,433,938.60	103.84
210102	Нэмэгдэл	275,700,300.00	260,486,333.30	94.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,256,400.00	3,131,310.00	96.16
210104	Урамшуулал	75,756,200.00	65,747,186.78	86.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,919,400.00	130,919,400.00	100
210201	Тэтгэврийн даатгал	92,206,600.00	92,206,600.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	9,678,200.00	9,678,200.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,742,600.00	7,742,600.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,935,600.00	1,935,600.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	19,356,400.00	19,356,400.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,698,900.00	115,110,052.06	86.1
210301	Гэрэл, цахилгаан	13,678,900.00	10,256,008.06	74.98
210302	Түлш, халаалт	60,863,400.00	49,750,000.00	81.74
210303	Цэвэр, бохир ус	59,156,600.00	55,104,044.00	93.15
2104	Хангамж, бараа материалын зардал	8,125,500.00	8,012,700.00	98.61
210401	Бичиг хэрэг	804,200.00	835,300.00	103.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,210,800.00	1,277,000.00	105.47
210404	Ном, хэвлэл	643,400.00	850,000.00	132.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	321,700.00	192,000.00	59.68
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,145,400.00	4,858,400.00	94.42
2105	Нормативт зардал	2,227,300.00	2,011,900.00	90.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	815,200.00	813,500.00	99.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,412,100.00	1,198,400.00	84.87
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,449,700.00	3,449,500.00	99.99
210604	Урсгал засвар	3,449,700.00	3,449,500.00	99.99
2107	Томилолт, зочны зардал	804,200.00	64,000.00	7.96
210702	Дотоод албан томилолт	804,200.00	64,000.00	7.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,970,800.00	1,490,600.00	50.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,490,600.00	1,490,600.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,480,200.00		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,914,800.00	13,582,560.00	97.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	981,300.00	665,000.00	67.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,933,500.00	12,917,560.00	99.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,630,000.00	54,001,375.45	97.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,630,000.00	54,816,400.00	98.54
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		-813,600.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,869,800.00	53,869,800.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,200.00	1,760,200.00	100

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох			
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		-815,024.55	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		-815,024.55	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			
	Дотоод эх үүсвэрээр			
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,314,562,900.00	1,314,449,192.00	99.99
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,175,799,900.00	1,175,799,900.00	100
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,175,799,900.00	1,175,799,900.00	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	137,148,500.00	137,148,500.00	100
132001	Орон нутгийн төсвөөс	137,148,500.00	137,148,500.00	100
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих			
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,614,500.00	1,500,792.00	92.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,614,500.00	1,500,792.00	92.96
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		515,000.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		365,000.00	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	100
3	Төсвийн байгууллага	1	1	100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	73	73	100
6	Удирдах ажилтан	1		
7	Гүйцэтгэх ажилтан	46	46	100
8	Үйлчлэх ажилтан	24	24	100
9	Гэрээт ажилтан	2	2	100
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ			

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,368,374.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,368,374.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,765,950.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,166,450.00
210401	Бичиг хэрэг	617,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	199,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,620,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,620,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,979,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,979,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,602,424.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,787,400.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,787,400.00
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	815,024.55
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	815,024.55

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Хэрлэнзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Суралцагчдын эрүүл мэнд хөгжлийг дэмжин, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд боловсролын харилцаанд оролцогчдын бүх талын оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, сургалтын үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТ хууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,175,799.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,636.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,345.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,996.4 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0
Бараа материал	85,385.7	109,219.3	23,833.6
Үндсэн хөрөнгө	4,728,093.4	4,710,495.8	-17,597.6
Нийт хөрөнгө	4,815,140.7	4,820,080.1	4,996.4
Өр төлбөр	0.0	0.0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,815,140.7	4,820,080.1	4,996.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,815,140.7	4,820,080.1	4,996.4

Бараа материалын данс 109,219.3 мянган төгрөг болж 23,833.6 мянган төгрөгөөр өссөн нь химийн кабинетийн хичээлийн хэрэглэгдэхүүн 9,960.7 мянган төгрөг, ном сурах бичиг 7,856.6 мянган төгрөгийн материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,710,495.8 мянган төгрөг болж 17,597.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн элэгдэлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,820,080.1 мянган төгрөг болж 4,996.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Ерөнхий боловсролын 20 дугаар сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,314,562.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,314,562.9 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 1,314,562.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,175,799.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 1,254.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс 137,148.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,289,440.8 мянган төгрөгийг зарцуулж, 18,589.0 мянган төгрөгийг улсын төсөвт, 5,775.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,289,440.8 мянган төгрөг буюу 98.09 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бага ангийн төсөл хөтөлбөрөөр 11,767.3 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна. Үүнээс бичиг хэргийн зардалд 617.3 мянган төгрөгийг, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 350.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 199.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 6,620.0 мянган төгрөг, хичээл практикийн зардалд 3,979.5 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн 20 дугаар сургуулийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансанд байршуулсан 151 мэдээллээс Худалдан авах ажиллагааны тайлан бүтэн жилээр хэсгийн мэдээллийг оруулаагүй, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 138.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 15,247.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 13,527.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	138.2	1	138.2			
Албан шаардлага	2	15,247.0	2	15,247.0			
Зөвлөмж	3	13,527.71	3	231.8			
Нийт дүн	6	2,864.4	5	2,864.4			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн 20 дугаар сургуулийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 53,455.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,407.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 50,048.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийгээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Үндсэн хөрөнгө худалдаж авсан 3,407.5 мянган төгрөгийн зардлыг хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дансанд бүртгээгүй тайлагнасныг холбогдох дансанд залруулж тайлагнуулав.

4.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд байгууллагын дотоод журмын шагнал, урамшуулал олгох заалтад тусгаагүй 7 ажилтанг 252.0 мянган төгрөгөөр шагнаж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Байгууллагын дотоод журмын 9.2.3-д “сургуулийн оны тэргүүний багш, ажилтан нэг, нэг хүнийг шалгаруулж, мөнгөн шагнал, хүндэтгэлийн тууз гардуулж, хүндэт самбарт зургийг нь тавьж алдаршуулна”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3.-д “....., цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх,” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Шилэн дансны мэдээллийн Худалдан авах ажиллагааны тайлан хэсэгт 49,796.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээллийг оруулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.8.2.-д "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан гэж" заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Жилийн эцсийн тооллогыг 9 сарын 23-нд хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1.-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жилийн эцсийн тооллогыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн 20 дугаар сургууль	4	53,455.9	1	3,407.9			50,048.0	2	1	



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 76/тх - 012 - 2022/63/НА-СТА-ТШЗ-Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 20 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны мэдээлэлд 49,796,000 төгрөгийн тендерийн Худалдан авах ажиллагааны тайлан мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.8.2-д "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээлэл оруулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 20 дугаар сургуулийн захирал Л.Очирсүрэн, нягтлан бодогч Б.Бямбацогт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ЭРДЭНЭ

АУДИТОР О.ХЭРЛЭНЗАЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 74/2022-ОрА - 2022/63/НА - СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 20 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын дотоод журмын шагнал, урамшуулал олгох заалтад тусгаагүй 7 ажилтанг 252,000 төгрөгөөр шагнаж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Байгууллагын дотоод журмын 9.2.3-д "сургуулийн оны тэргүүний багш, ажилтан нэг, нэг хүнийг шалгаруулж, мөнгөн шагнал, хүндэтгэлийн тууз гардуулж, хүндэт самбарт зургийг нь тавьж алдаршуулна," Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д "..... цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 20 дугаар сургуулийн захирал Л.Очирсүрэн, нягтлан бодогч Б.Бямбацогт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... О.ХЭРЛЭНЗАЯА

